



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/573

Есөнбулаг сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн УТ2501900234005/04-466 дугаар гэрээт Шарга, Есөнбулаг сумдад 2 ширхэг инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Ж.Очир (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Ж.Билэгсайхан (Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн)
Б.Батхуяг (Хүйсийн говь цэцэг нуурын сав газрын захиргааны газрын доорх усны нөөц хяналт шинжилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Есөнбулаг, Шарга сумдын Засаг дарга)

Д.Жаргалсайхан ("Гранд холдинг" ХХК-ын гүйцэтгэх захирал)

Нарийн бичгийн дарга: Э.Пүрэвдорж (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Малын бэлчээрийн менежментийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Худгийг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсаны дагуу холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Ж.Очир)-т үүрэг болгосугай.

3. Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг паспортжуулан бүртгэж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг тухайн сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

